

# ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АЙМГУУДЫН ЗДТГ

2017 ОНЫ 2 ДУГААР САРД


Монгол Улсын 21 аймгийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгааг орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж байна. Хуулиар ЗДТГ-уудын нийтэд ил тод болгох ёстой мэдээллүүдээс зургааг нь сонгон авч 2017 оны 2 дугаар сарын туршид тэдгээр мэдээллийг хэрхэн ил тод болгож байгааг ажиглав.

## АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН




1 дүгээр сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 5 аймгийн ЗДТГ бүрэн мэдээлж байсан бол 2 дугаар сард 11 аймгийн ЗДТГ 100 хувь нийтэлсэн ахиц гарчээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу аймгуудын ЗДТГ-ын 2017 оны 2 дугаар сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2-ыг үзнэ үү).




Тайлбар: 1 🏠 = 10%

### ЦАЛИНГААС БУСАД 5 САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ОРЛОГО, ЗАРЛАГЫН МЭДЭЭЛЭЛ



1 дүгээр сард зөвхөн 3 аймгийн ЗДТГ орлого, зарлагын гүйлгээнд холбогдох шийдвэрийг нийтэлж байсан бол 2 дугаар сард 9 аймгийн ЗДТГ нийтэлсэн ахиц гарчээ.



Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу худалдан авалтын мэдээллийг 6 аймгийн ЗДТГ нийтэлжээ (Тайлбар 1-ийг үзнэ үү). Мэдээлэл нийтлээгүй зарим ЗДТГ "тухайн сард 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт хийгдээгүй" гэсэн тайлбар өгчээ.

Тайлбар: 1 🏠 = 1 мэдээлэл

Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зөвхөн 5 аймгийн ЗДТГ хугацаанд нь нийтэлжээ. Харин 2 дугаар сард Хэнтий аймгийн ЗДТГ уг төлөвлөгөөг хугацаа хоцорч нийтэлсэн бол бусад аймаг ил болгоогүй хэвээр байна. 2017 оны 2 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Баян-Өлгийгөөс бусад аймгийн ЗДТГ хуулийн хугацаанд нь буюу 3 дугаар сарын 8-ны дотор ил тод болгожээ.

#### Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- 5 сая төгрөгөөс дээш дүнтэй худалдан авалт болон гүйлгээний тоог гаргахдаа ЗДТГ-ын шилэн дансанд нийтлэгдсэн мэдээллээс зөвхөн үүнд хамааралтайг түүвэрлэж авсан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 2 дугаар сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

#### АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас
- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мониторингийн дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудаснаас үзнэ үү.